

Бригам Янгийн жишээ

1-р ярилцлага ИЛТГЭХ ЧАДВАРЫН СОРИЛТ

Дараахтай төстэй асуултыг тавьснаар эхэл.

- Та илтгэл тавих талаар ямар бодолтой байдаг вэ? Яагаад?

Дараахыг унш эсвэл нэгтгэн дүгнэ.

Бригам Янгад тохиолдож байсан хамгийн хүнд сорилтуудын нэг бол илтгэл тавих байсан. Тэрээр: “Би хэл яриандаа хамгийн тааруу хүмүүсийн нэг байлаа” гэж хэлжээ (*Journal of Discourses*, 5:97). Баптисм хүртсэнийхээ дараагийн долоо хоногт тэрээр Сүмийн гишүүн байсан дөрвөн туршлагатай илтгэгчийг номлохоор ирнэ гэж хүлээж байсан ч ирээгүй гэж дурссан байдаг. Тэрээр ийн ярьсан байдаг.



Би илтгэл тавихдаа, басертөнцийн талаарх мэдлэгийн хувьд нялхаараа байв. Гэвч Их Эзэний Сүнс миний дээр байсан бөгөөд би үзэж, сонсож, сурсан—туулж, баяссан зүйлээ хүмүүст ярьж хэлэхгүй л бол яс минь янгинах мэт мэдэрч, тэгээд анхны илтгэлээ нэг цаг гаруй тавьсан. Намайг амаа ангайхад л Их Эзэн дүүргэж байв. (Бригам Янг, *Journal of Discourses*, 13:211)

- Бригам Янгийн хийсэн зүйлийн юу нь хэцүү байсан бэ?

Суралцагчдыг Сургаал ба Гэрээ 100:5–6 (мөн Гэтлэл 4:12; Сургаалт үгс 16:1-ийг үзнэ үү)-г уншихад урь. Тэгээд дараах асуултыг тавь.

- Бригам Янгад тохиолдож байсан зүйлүүд хэрхэн эдгээр шүлэгтэй хамааралтай вэ?

- Та Их Эзэн өөрт тань тусалж чадах юуны талаар мэдэж авсан бэ?

Их Эзэнд итгэх, мэддэг зүйлээ хуваалцах хүсэлтэй байх талаар ямар бодолтой байгаагаа хуваалц.

2-р ярилцлага БРИГАМ ҮЙЛЧЛЭХИЙН ТӨЛӨӨ ЗОЛИОС ГАРГАСАН НЬ

Дараахтай төстэй асуулт тавьж эхлүүлээрэй.

- Номлолд үйлчлэхэд ямар золиос гаргах хэрэгтэй болдог вэ?

Дараахыг унш эсвэл нэгтгэн дүгнэ.

Бригам Янгийг баптисм хүртсэн жил эхнэр нь нас барав. Их золиослол гарган, тэрээр хоёр хүүхдээ бусдын асрамжинд орхин, Нью-Йоркод болон дээд Канадын олон номлолд үйлчилж, тэндээ хэд хэдэн хүнд баптисм хүртээжээ.

Нэг жил орчим номлолд үйлчилснийхээ дараа Бригам Охайогийн Көртландад ирсэн тухайгаа ийн тайлбарлав.



Гэгээнтнүүдтэй хамт цугларсан хэн нэгэн хүн надаас илүү ядуу байсан бол энэ нь түүнд юу ч байхгүй байсантай холбоотой. . . . Надад харж асрах ёстой хоёр хүүхэд байсан. . . . Би бэлэвсэрсэн байсан. . . . [Миний хөлд] зээлсэн гуталнаас өөр гутал байгаагүй. Гурав, дөрвөн жил өмссөн гараараа оёсон хүрмээс өөр өвлийн хувцас надад байгаагүй. Би аялж, номлож, өөртөө байсан өмчийнхөө доллар бүрийг зарцуулсан байсан. (*Teachings of Presidents of the Church: Brigham Young* [1997], 243)